ҮНДЭСНИЙ ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ХИЙМЭЛ ДАГУУЛ ТӨСӨЛД УРЬДЧИЛСАН САНАЛ АВАХ ХҮСЭЛТ

Зорилго

Монгол Улсын Их Хурлын 2026 оны 35 дугаар “Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын хэрэгжилтийг хангах, үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн шинэчилсэн техник, эдийн засгийн үндэслэл болон цаашдын сонгон шалгаруулалтын шаардлагыг боловсруулах хүрээнд хиймэл дагуул, сансрын технологи, харилцаа холбооны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниудаас мэдээлэл, урьдчилсан санал авах зорилготой.

Энэхүү мэдээлэл, санал авах ажиллагаа нь зах зээлийн урьдчилсан судалгаа, боломжит технологи болон нийлүүлэгчийг тодорхойлох зорилготой бөгөөд тендер, худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалт, гэрээ байгуулах урилга биш болно.

2. Төслийн ерөнхий мэдээлэл

Үндэсний хиймэл дагуулын төслийн хүрээнд Монгол Улсын хэрэгцээнд нийцсэн орчин үеийн холбооны хиймэл дагуулын шийдлийг судалж байгаа бөгөөд дараах үндсэн асуудлыг авч үзнэ:

- Монгол Улсын өнөөгийн болон ирээдүйн харилцаа холбооны хэрэгцээ;
- Өргөн зурвасын болон алслагдсан бүсийн харилцаа холбоо;
- Хил орчмын болон гамшгийн үеийн холбоо;
- Төрийн болон арилжааны хэрэглээ;
- Үндэсний аюулгүй байдлын шаардлага;
- Орбит, давтамж болон олон улсын зохицуулалт;
- Хиймэл дагуул, газрын дэд бүтэц, хөөргөлт, даатгал, ашиглалт, засвар үйлчилгээ.

3. Мэдээлэл, урьдчилсан санал авах үндсэн чиглэл

№	Чиглэл	Хүсэж буй ерөнхий мэдээлэл
1	Хиймэл дагуулын шийдэл	Төрөл, технологи, хүчин чадал, хамрах хүрээ, ашиглалтын хугацаа, өргөтгөх боломж
2	Газрын дэд бүтэц	Gateway, TT&C, NOC, хэрэглэгчийн тоног төхөөрөмж болон бусад шаардлагатай байгууламж
3	Хөөргөлт	Хөөргөлтийн үйлчилгээ, пуужин, боломжит хугацаа, тойрог замд оруулах үйлчилгээ

4	Даатгал	Хөөргөлт болон тойрог замын даатгалын үндсэн шийдэл, нөхцөл
5	Ашиглалт, засвар үйлчилгээ	Техникийн дэмжлэг (O&M) сургалт, мэргэжилтэн бэлтгэх, технологи дамжуулалт
6	Давтамж, орбит	113.6°E байрлал, боломжит давтамжийн зурвас, ОУЦХБ-ын зохицуулалтын дэмжлэг
7	Санхүүгийн мэдээлэл	Урьдчилсан үнэ, зардлын үндсэн бүтэц, боломжит санхүүжилтийн хувилбар
8	Хэрэгжүүлэх хугацаа	Үйлдвэрлэл, газрын дэд бүтэц, хөөргөлт, туршилт, ашиглалтад оруулах ерөнхий хугацаа

4. Компаниас ирүүлэх мэдээллийн бүтэц

№	Ирүүлэх мэдээлэл
1	Компанийн товч танилцуулга, холбогдох туршлага
2	Санал болгож буй хиймэл дагуулын ерөнхий шийдэл
3	Хүчин чадал болон хамрах хүрээ
4	Газрын дэд бүтцийн шийдэл
5	Хөөргөлтийн шийдэл
6	Даатгалын үндсэн нөхцөл
7	Ашиглалт, засвар үйлчилгээ
8	Давтамж, ОУЦХБ-ын асуудлаар үзүүлэх дэмжлэг
9	Урьдчилсан үнэ, зардлын мэдээлэл
10	Санхүүжилтийн боломж
11	Хэрэгжүүлэх ерөнхий хугацаа
12	Ижил төстэй төслийн туршлага, лавлагаа

5. Урьдчилсан техникийн мэдээллийн маягт

Үзүүлэлт	Урьдчилсан шаардлага	Компанийн санал
Орбит	GEO / 113.6°E	
Анхны хүчин чадал	≥50 Гбит/сек	
Өргөтгөх боломж	Шаардлагатай	
Давтамж	Ku/Ka/бусад	
Хамрах хүрээ	Монгол Улс	
Ашиглалтын хугацаа	Санал болгох	
Дамжуулах гарц (Gateway)	Шаардлагатай	
Удирдлага, хяналт (TT&C)	Шаардлагатай	
Сүлжээний удирдлагын төв (NOC)	Шаардлагатай	
Хөөргөлт	Шаардлагатай	
Даатгал	Шаардлагатай	
Кибер аюулгүй байдал	Шаардлагатай	

Ашиглалт ба засвар үйлчилгээ (O&M)	Санал болгох	

6. Урьдчилсан санхүүгийн мэдээллийн маягт

Зардлын төрөл	Урьдчилсан дүн, USD	Тайлбар
Хиймэл дагуул		
Хөөргөлт		
Даатгал		
Газрын дэд бүтэц		
Газрын дэд бүтэц (NOC/TT&C)		
Сургалт		
Зөвлөх үйлчилгээ		
Ашиглалт, засвар үйлчилгээ		
Бусад		
Нийт урьдчилсан өртөг		

Энэ шатанд нарийвчилсан 15 жилийн үйл ажиллагааны зардал болон санхүүгийн тооцоолол заавал шаардахгүй бөгөөд зардлын үндсэн бүтэц, урьдчилсан үнийн хүрээг авахад чиглэнэ.

7. Санхүүжилтийн боломж

- Засгийн газрын хөнгөлттэй зээл
- Хөнгөлөлттэй зээл болон бусад боломжит санхүүжилтийн хэлбэр
- Экспортын санхүүжилт
- Экспортын зээлийн баталгаа
- Нийлүүлэгчийн санхүүжилт
- Арилжааны зээл
- Лизинг

8. Холбоо барих мэдээлэл

Байгууллага	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
Хариуцах нэгж	Хууль, эрх зүй, хамтын ажиллагааны хэлтэс
Холбоо барих ажилтан	Л.Нямдорж

И-мэйл	space@mddic.gov.mn болон fr@mddic.gov.mn
Утас	+976 51 260636 and +976 51 265104

9. Анхаарах зүйл

Компаниас ирүүлсэн мэдээлэл нь төслийн шинэчилсэн техник, эдийн засгийн үндэслэл, зах зээлийн судалгаа болон цаашдын сонгон шалгаруулалтын шаардлагыг боловсруулахад ашиглагдаж болно. Энэхүү Мэдээлэл ирүүлэх хүсэлт нь цаашдын сонгон шалгаруулалтад оролцох эрх, гэрээ байгуулах баталгаа болохгүй. Шаардлагатай тохиолдолд нууц хадгалах гэрээ (NDA) хоёр тал байгуулж болно.